



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2022 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 448

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа,  
үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 117,322,586.89 (нэг зуун арван долоон сая гурван зуун хорин хоёр мянга таван зуун наян зургаан төгрөг наян есөн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий Автокран Камаз маркийн, 62-26 УБК улсын дугаартай, ХТС53228N32188625 арлын дугаартай автомашины ашиглах хугацааг 5 жилээр сунгаж, үнийг 5,000,000.00 (таван сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу, "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Н.Мөнгөнхөлөгт нарт дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх;

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132003225

24-ndraldaan.docx